



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/448

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлийн 1.3.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор хөтөлбөрийн 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Норвеги улсын Осло хотноо 2021 оны 10 дугаар сарын 02-10-ны өдрүүдэд зохион байгуулагдах насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Олон улсын хэмжээний мастер Э.Дэлгэрмаа, чөлөөт бөхийн мастер Н.Загардулам нарын замын зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100949

D:My Doc. Zahiramj. Zasag darga